



**АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН МЭРГЭЖЛИЙН ХОЛБОО
НИЙТИЙН ЭРХ ЗҮЙН ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН
УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2026 оны 02 сарын 05 өдөр

Дугаар 3/1526

Улаанбаатар хот

Үүрэг болгох тухай

Аялал жуулчлалын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1 дахь хэсэг, Аялал жуулчлалын мэргэжлийн холбооны дүрмийн 28 дугаар зүйлийн 28.1.11 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Аялал жуулчлалын мэргэжлийн холбоо” НЭЗХЭ-ээс жил бүр зохион байгуулдаг “Tourism Week” арга хэмжээг зохион байгуулахдаа дараах зүйлсийг хийж хэрэгжүүлэхийг Гүйцэтгэх захирал М.Нарангэрэлд үүрэг болгосугай.
 - a. Арга хэмжээнд оролцох тасалбарын үнэ мэргэжлийн холбооны гишүүдэд хямдралтай байх,
 - b. Оролцох сонирхолтой этгээд оролцохыг хүссэн өдрөө чөлөөтэй сонгодог байх боломжийг нээх,
 - c. Олон нийтэд арга хэмжээний талаарх мэдээллийг ойлгомжтой хүргэх,
 - d. Арга хэмжээнд дэмжлэг үзүүлэх сонирхолтой байгууллагад зориулсан багц гаргах,
2. “Tourism Week” арга хэмжээний хэлэлцүүлгийн хэсэгт зориулж өөрийн харьяалах асуудлаар тодорхой хэлэлцүүлгийн сэдвүүдийг тодорхойлж өгөхийг Удирдах зөвлөлийн дэргэдэх чиг үүргийн хороодод үүрэг болгосугай.
3. “Tourism Week” арга хэмжээнд бүх төрлийн дэмжлэг үзүүлэн ажиллахыг “Аялал жуулчлалын мэргэжлийн холбоо” НЭЗХЭ-ийн удирдах зөвлөлийн бүх гишүүдэд үүрэг болгосугай.

УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



О.МӨНХНАСАН